




2024 APR

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ АЛБА

Урин дулаан цагийг угтаж 4-р сарын онцлох статистик мэдээллүүдтэй танилцацгаая.

БНХАУ-ЫН ЭДИЙН ЗАСАГ

- БНХАУ-ын эдийн засаг 1-р улиралд 5.3 хувиар тэлж шинжээчдийн таамаг болох 4.8 хувийг давжээ. Ийнхүү өсөхөд нэг болон хоёрдугаар сарын эдийн засгийн үйл ажиллагааны идэвх голлон нөлөөлсөн ба гуравдугаар сард жижиглэн худалдаа, аж үйлдвэрийн гарц хүлээлтэд хүрээгүй байна. Мөн 3-р сард БНХАУ-ын экспорт 7.5 хувиар, импорт 1.9 хувиар тус тус буурчээ. Удаан үргэлжилсэн үл хөдлөх хөрөнгийн хямрал, дефляцид ороод буй үйлдвэрийн үнэ зэрэг нь хэрэглэгчдийн итгэл, худалдан авалт саарахад хүргэж байна.

ЖЭРОМ ПАУЛЛ-ЫН МЭДЭГДЭЛ

- АНУ-ын инфляц 3-р сард 3.8 хувьд хүрснээр сүүлийн 6 сарын хамгийн өндөр түвшинд хүрчээ. АНУ-ын Холбооны Нөөцийн Сангийн тэргүүн Жером Пауэлл инфляц төсөөллөөс хурдан буурч байгаа ч зорилтот хоёр хувиас өндөр байгаа нь бодлогын хүүг хянуур бууруулах дохио болж байгааг мэдэгджээ. Мөн ХНС-аас бодлогын хүүг энэ жилдээ багтааж 3 удаа бууруулах хүлээлттэй байгаа аж.

ИНФЛЯЦ

- Өнгөрсөн оны мөн үед инфляцын түвшин 12.2 хувьтай байсан ба үүний 42.6 хувийг импортын барааны үнийн өсөлт бүрдүүлж байжээ. Харин 2024 оны 3-р сарын инфляц 7 хувьтай гарсан ба 2.4 нэгж хувь буюу 34 хувийг импортын бараа, бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлсэн байна. Ийнхүү импортын барааны үнийн өсөлт буурснаар 4 сар дараалан инфляцын түвшин Монгол банкны зорилтот 6 +/-2 түвшинд хадгалагдлаа.

ГАДААД ХУДАЛДАА

- 2024 оны эхний 3 сарын байдлаар буюу эхний улиралд нийт экспорт 3.7 тэрбум ам.долларт, нийт импорт 2.4 тэрбум ам.долларт хүрснээр худалдааны тэнцэл 1.3 тэрбум ам.долларын ашигтай гарлаа. Улмаар өмнө оны мөн үетэй харьцуулахад нийт экспорт 1 хувиар буурсан, нийт импорт 25 хувиар өссөн үзүүлэлттэй байна.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүний экспорт бүрдүүлсэн ба тэр дундаа 60 хувийг нүүрсний экспорт, 17 хувийг зэсийн экспорт бүрдүүлжээ. Нүүрсний экспортын биет хэмжээ эхний улиралд 17.7 сая тонн-д хүрч өмнө оны мөн үеэс 28 хувиар нэмэгдсэн ч хилийн үнийн бууралтаас шалтгаалж жилийн өмнөх үетэй харьцуулахад нийт экспортын хэмжээ 1.4 хувиар буурчээ. Мөн цаг уурын эрс тэрс байдал, ган зуд тохиолдсонтой холбоотойгоор хөдөө аж ахуйн салбар уналтад орж хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний экспорт 14 хувиар буурсан байна.
- Нийт импортын өсөлтөд голлон хэрэглээний бараа бүтээгдэхүүн, машин механизм, барилгын материал, шатахууны импортын өсөлт нөлөөлжээ. Өмнө оны мөн үетэй харьцуулахад нийт импорт 475 сая ам.доллараар нэмэгдсэн ба үүний 28.4 хувийг урт хугацаат хэрэглээний барааны импорт, 24.4 хувийг тээврийн хэрэгслийн импорт, 16.1 хувийг дизел бензиний үнийн өсөлт бүрдүүлсэн байна.

ГАДААД ВАЛЮТЫН АЛБАН НӨӨЦ, ХАНШ

- Гадаад валютын албан нөөц 3-р сард 5.2 тэрбум ам.доллартой гарснаар түүхэн дээд хэмжээнд хүрлээ. Хэдий валютын нөөцийн хэмжээ нэмэгдэж байгаа ч сүүлийн саруудад хэрэглээний барааны импорт өсөж байгаа болон дэлхийд түүхий эдийн үнэ буурч байгаа зэрэг нь эрсдэл үүсгэж байна. /Б.Лхагвасүрэн, МБ ерөнхийлөгч/
- Жилийн өмнөх мөн үед валютын нөөц 3.4 тэрбум ам.доллар байсан ба энэ нь 4.6 сарын импортын барааг нөхөх хэмжээнд байсан бол одоогийн түвшинд 5.2 тэрбум ам.долларын нөөц 6.4 сарын импортын барааг авж болохуйц байна. Валютын нөөц үнэмлэхүй нэмэгдэж байгаа ч нөгөө талдаа мөн импортын өсөлт эрсдэл үүсгэж буй юм.
- Ийнхүү төгрөгийн ханш алгуур чангарсан хэвээр байгаа ба 3-р сарын эцсийн байдлаар төгрөгийн ам.доллартой харьцах ханш 3'3376 төгрөг байна. Жилийн өмнөх мөн үед нэг ам.доллар тутамд 3'518 төгрөг ногдож байжээ.

УЛСЫН ТӨСӨВ

- Эхний 3 сарын байдлаар төсвийн орлого 7.3 их наяд төгрөгт, төсвийн зардал 5.7 их наяд төгрөгт хүрснээр төсвийн тэнцэл 1.6 их наяд төгрөгийн ашигтай гарлаа. Төсвийн тэнцэл ашигтай гарахад татварын нийт орлого, тэр дундаа эрдэс бүтээгдэхүүний экспорт нэмэгдэж, зарим төрлийн импорт нэмэгдсэн голлон нөлөөлжээ. Төсвийн тэнцэл ирэх саруудад ч мөн ашигтай гарах хүлээлттэй байгааг Азийн Хөгжлийн Банкнаас мэдээлсэн. Гэсэн хэдий ч Монгол банкны мэдэгдэж буйгаар төсвийн зарлага өсөж байгаа мөн дөрөвдүгээр сараас эхлэн нэмэгдсэн цалин, тэтгэврийн өсөлт инфляцад дарамт учруулж байна.

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ, БАНК САНХҮҮ

- Мөнгөний нийлүүлэлт 3-р сарын байдлаар 37.4 их наяд төгрөгт хүрснээр жилийн мөн үеэс даруй 21 хувиар нэмэгджээ. Ийнхүү нэмэгдэхэд төгрөгийн харилцах, хадгаламж 8 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь голлон нөлөөлөв. Төгрөгийн ханш чангарснаар валютын харилцах, хадгаламж бууралттай хэвээр байна.
- Гуравдугаар сарын эцсийн байдлаар валютаар байршуулсан хадгаламжийн үлдэгдэл 4.3 их наяд төгрөгтэй тэнцэж байгаа нь өмнөх оны мөн үеэс 1.4 их наяд төгрөгөөр буурсан дүн болж байна. Мөн валютын харилцах дансны үлдэгдэл таван их наяд ам.доллар болж, 134 сая ам.доллароор буурчээ.
- Арилжааны банкнуудын зээлийн дундаж хүү 17 хувь, хадгаламжийн дундаж хүү 12 хувьтай байна. Цаашлаад бодлогын хүү 12 хувь болж буурснаар ирэх улиралд арилжааны банкнууд цаашдын зээл болон хадгаламжийн хүүд өөрчлөлт оруулах хүлээлттэй байна.

ОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГУУДЫН ТААМАГЛАЛ

- Монгол улсын 2024 оны эдийн засгийн өсөлтийг ОУВС-аас 6.5 хувь, Дэлхийн банк 4.8 хувь, Монгол банк 3.8 хувь, Азийн Хөгжлийн Банкнаас 5.9 хувьд хүрэх төсөөлөл тавьжээ. Ийнхүү эдгээр байгууллагуудын дундаж төсөөллөөр эдийн засгийн өсөлт 2024 оны эцэст 5.3 хувьд хүрэх хүлээлттэй байна. Мөн ОУВС-аас 2023 оны төсвийн тодотголын бүтэн жилийн нөлөөлөл болон энэ оны цалин, тэтгэврийн нэмэгдэл, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн ногдол ашиг тараалтын нөлөө нь ойрын хугацаандаа өсөлтийг өдөөх төлөвтэй ч ирэх жилүүдээс гадаад хүчин зүйлсийн дарамт нь өндөр инфляцтай хавсарснаар эдийн засгийн өсөлтийг сааруулж эхэлнэ гэж таамагласан байна.
- Мөн олон жилийн дараа анх удаа ашигтай гарсан урсгал дансны тэнцлийн хувьд нүүрсний үнийн уналт, импортын бараа, бүтээгдэхүүний өсөлтийн улмаас эргээд томоохон алдагдалтай гарах төлөвтэй тул гадаад валютын албан нөөц 2023 оны сүүл үеийн түвшнээсээ (4.8 тэрбум ам.доллар) төдийлөн өсөхгүй гэж үзжээ.
- Цаашлаад бусад томоохон байгууллагуудаас зудаас шалтгаалсан ХАА салбарын хүндхэн нөхцөл байдал эдийн засгийн өсөлтийг хойш татна гэж үзжээ. Хятадын үл хөдлөх хөрөнгийн салбарын хямрал ойрх орнуудын, дан ялангуяа Монгол улсын эдийн засагт сөргөөр нөлөөлөх юм.


ХУРААНГУЙ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2023Q4	2023Q3	2022Q4	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	30,454	21,695	28,455	7.0%
Ажилгүйдлийн түвшин	%	3.92%	5.24%	5.28%	-25.8%
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг	2,235	2,009	1,750	27.7%
Гадаад өр	сая ам доллар	34,570	33,991	33,586	2.9%
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M03	2024M02	2023M03	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам доллар	3,720	2,240	3,764	-1.2%
Зэс	сая ам доллар	638	445	632	1.0%
Нүүрс	сая ам доллар	2,213	1,336	2,244	-1.4%
Нийт импорт	сая ам доллар	-2,414	-1,596	-1,940	24.5%
Хэрэглээ	сая ам доллар	-726	-507	-573	26.7%
Түүхий эд	сая ам доллар	-222	-152	-189	17.4%
Хөрөнгө оруулалт	сая ам доллар	-905	-567	-752	20.4%
Шатахуун	сая ам доллар	-557	-367	-423	31.6%
Тэнцэл	сая ам доллар	1,306	644	1,824	-28.4%
Дэлхийн түүхий эдийн үнэ					
Зэс	\$/тонн	8,693	8,305	8,856	-1.8%
Нүүрс	\$/тонн	138	129	196	-29.7%
Газрын тос	\$/баррель	85	82	79	7.2%
Алт	\$/трой унц	2,162	2,024	1,914	13.0%
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцэл	тэрбум төгрөг	1,591	1,343	657	142.3%
Төсвийн орлого	тэрбум төгрөг	7,286	5,102	4,795	52.0%
Төсвийн зардал	тэрбум төгрөг	-5,695	-3,759	-4,138	37.6%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2024M03	2024M02	2023M03	
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	37,400	37,603	30,939	20.9%
ХҮИ (C2015)	индекс	142.9	141.6	133.6	7.0%
Бодлогын хүү	%	12.0%	13.0%	13.0%	-7.7%
Хүү ба ханш					
Ам долларын ханш (Эцсийн)	Төгрөг/\$	3,376	3,382	3,518	-4.0%
Төгрөгийн хадгаламж	%	11.9%	11.4%	10.5%	12.8%
Валютын хадгаламж	%	3.2%	3.9%	3.0%	7.8%
Төгрөгийн зээл	%	17.0%	17.0%	16.7%	2.0%
Валютын зээл	%	10.7%	9.4%	10.3%	3.8%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам доллар	5,250	4,971	3,438	52.7%


БОДИТ ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

■ Бодит ДНБ-ны өсөлт (C2015)




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

АЖИЛГҮЙДЭЛ БА ЦАЛИН




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ГАДААД ХУДАЛДААНЫ ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Монголбанк

ДЭЛХИЙН ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНЭ




Эх сурвалж: ОУВС

УЛСЫН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УЛСЫН ГАДААД ӨР




Эх сурвалж: Монголбанк

ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ




Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

МӨНГӨНИЙ НИЙЛҮҮЛЭЛТ




Эх сурвалж: Монголбанк

УЛСЫН ИНФЛЯЦ




Эх сурвалж: Монголбанк

ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ



Эх сурвалж: Монголбанк

АМ ДОЛЛАРЫН ХАНШ



Эх сурвалж: Монголбанк

БАНКУУДЫН ДУНДАЖ ХҮҮ



Эх сурвалж: Монголбанк



ЕРӨНХИЙ ЭДИЙН ЗАСАГЧ

Ө. Мөрөн

Цахим хаяг: murun_u@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Анунжин

Цахим хаяг: anunjin.ba@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

Б. Дархлан

Цахим хаяг: darkhlan@golomtbank.com

ЭДИЙН ЗАСГИЙН ШИНЖЭЭЧ

О. Номуншүр

Цахим хаяг: nomunshur@golomtbank.com

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны алба нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.